



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 8/37

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйл, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/28 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Багахангай дүүргийн нэгдүгээр хорооны 2, 3, 4, 5, 6 дугаар байр, хоёрдугаар хорооны 5, 6, 7, 8, 9, 12, 13, 16 дугаар байрны орон сууцнуудын фасадны өнгө сэргээх засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга Б.Болормаа

Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Г.Батням

Багахангайн Үйлдвэрлэл технологийн парк УТҮГ-ын няглан бодогч

Д.Баасанжав

1 дүгээр хорооны иргэн

Нарийн бичиг

Э.Урансайхан

Худалдан авах ажиллагааны албаны худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Б.Болормаа)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СУХБОЛД